

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	22
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Г.САРАНТУЯА ТАНАА

2019.02.25 № 06/237
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Сарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал татахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, СМД аудит ХХК-ийн аудитор Д.Гэндэнпэлжээ ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “СМД аудит” ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1/07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн нь “эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан ус, цаг уур, уур амьсгал, байгаль орчны судалгааны болон бодит, урьдчилсан мэдээ, мэдээллээр үйлчлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Ус цаг уур, байгаль орчны мэдээ, мэдээллээр хангах

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн багц хуулиуд
- Хөдөлмөрийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай
- Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Шинжлэх ухаан, технологийн хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous санхүүгийн тооцоолох” програм хангамж ашигладаг байна.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй

гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг тооцохдоо, төсвийн байгууллага тул 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Эрсдэл бага гэж үзсэн учир, материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар сонгох нь зүйтэй гэж үзэв.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 825,699.4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 16,513.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд 1 алдаа залруулсан.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	3,035.5	
	Дүн	2	3,035.5	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 166 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,176,842.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 147 мэдээллийг хугацаанд нь 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43 гүйлгээ байгааг тайлант хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 1 акт, 1 албан шаардлага өгсөн бөгөөд акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хэрэгжсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул санхүүгийн тайлангийн үр дүнд аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ус, цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Ерөнхий журналаас зардлын дансанд бичсэн хангамж, бараа материалыг шууд зардалд бичсэн гүйлгээ 9,284.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,118.9 мянган төгрөг нийт 14,403.2 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвөөс гадуур зардал гаргах, зориулалт бусаар зарцуулах, зардлыг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй байх, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн. Бүртгэлийн алдааг залруулав.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын 2018 оны 1-12 сард тайлагнасан цалингийн хүснэгтээр суутгасан хувь хүний орлогын албан татварын дүн 100,929.7 мянган төгрөг байна. Энэ нь “Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан” ТТ-11 маягтаар тайлагнасан төлбөл зохих татвараас 3,035.5 мянган төгрөгөөр дутуу байна. Шалтгаан нь хувь хүнтэй хийсэн гэрээний дагуу олгосон машины гражийн түрээс, машины түрээс гэх мэт орлогоос суутгаж авсан татварыг дээрх тайлангийн “гэрээгээр олгосон хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос суутган тооцсон татварын мэдээ” ТТ11-2 дугаар мэдээгээр тайлагнасантай холбоотой байна.

3.2.2 Эрсдэл:

Татварын тайлангийн төрлөөр татварын өглөг буруу илэрхийлэгдэх, мөн цалингийн зардалд хяналт хийхэд хүндрэл учруулах, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

“Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан” ТТ-11 маягтаар зөвхөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тайлагнаж бусад бараа бүтээгдэхүүний худалдан авалтаас татвар суутгасан орлогыг “Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайлан” ТТ- 12 маягтын 1 дүгээр мэдээгээр, татвар суутгаж аваагүй орлогын мэдээг 2 дугаар мэдээгээр тайлагнаж байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн харуу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна. Цалин хөлс түүнтэй адилтгах орлого болон, суутгагчийн хувь хүнд олгосон албан татварын тайланг тус тус маягтын дагуу тайлагнаж ажиллана.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын жижиг мөнгөн сангийн тайланг гаргахдаа “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны” журмын 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу “нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна” гэснийг мөрдөж ажиллаагүй. Мөн тус журмын 7.4-т заасны дагуу “Нягтлан бодогч нь төсвийн гүйцэтгэлийн болон өглөг, авлагын сар бүрийн мэдээ, тайланг харилцагч Төрийн санд гарган ирүүлэхдээ МГТ1 маягтаар тухайн сарын эцсийн өдрөөр тасалбар болгон бэлэн мөнгөөр хийгдсэн зарлага, санхүүжилтийн тайланг ирүүлнэ” гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т заасны дагуу “эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гээд, 70.2.4-т

“мөнгөн хөрөнгийг сар бүр /сар бүрийн 1-нээр/” тооллого явуулж байна гэсний дагуу сар бүр жижиг мөнгөн сангийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна.

3.3.2 Эрсдэл:

Мөнгөн кассын журмыг мөрдөөгүйгээс мөнгөн хөрөнгө дутагдах, тайлант хугацаанд гарсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буюу үйл явдал нөхцөл байдлуудыг бүртгэлгүй орхигдуулах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

“Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль болон “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны” журам, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх

3.3.4 Байгууллагаас өгсөн харуу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна. Мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>178,155,126.77</u>	<u>163,624,891.28</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	12,000,000.00	1,548,007.01
33300	Татаас, санхүүжилтийн авлага	12,000,000.00	-
335	Бусад авлага	-	1,548,007.01
3351	Байгууллагаас авах авлага	-	1,548,007.01
34	УРЬДЧИЛГАА	15,267,084.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	15,267,084.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	150,888,042.77	162,076,884.27
354	Хангамжийн материал	150,888,042.77	162,076,884.27
35410	Бичиг хэргийн материал	55,299,774.00	54,340,570.00
35420	Аж ахуйн материал	18,252,164.74	21,832,984.74
35430	Сэлбэг хэрэгсэл	76,114,202.94	83,984,528.44
35440	Түлш, шатах тослох материал	1.09	1.09
35450	Барилгын засварын материал	1,221,900.00	1,918,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>390,354,440.07</u>	<u>891,381,903.62</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	390,354,440.07	891,381,903.62
392	Биет хөрөнгө	389,908,373.37	891,264,603.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	440,795,520.00	614,852,711.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-284,680,439.99	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,575,250.00	66,575,250.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-64,711,237.48	-65,539,687.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,102,753,636.49	1,151,357,156.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	-917,756,793.84	-914,854,457.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	126,887,667.01	122,301,462.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-99,786,626.78	-102,278,963.27
39209	Зам, гүүрийн байгууламж	23,218,802.00	23,218,802.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-20,468,535.22	-21,448,801.87
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,209,833.60	1,209,833.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39217	Ном	15,871,297.58	15,871,297.58
393	Биет бус хөрөнгө	446,066.70	117,299.86
39301	Програм хангамж	165,999,151.22	75,294,346.72
39302	Хуримтлагдсан элэгдэл	-165,553,084.52	-75,177,046.86
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>568,509,566.84</u>	<u>1,055,006,794.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-

42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>568,509,566.84</u>	<u>1,055,006,794.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	568,509,566.84	1,055,006,794.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	568,509,566.84	588,922,571.51
51210	Өмнөх үеийн үр дүн	568,509,566.84	568,509,566.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	20,413,004.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	466,084,223.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>568,509,566.84</u>	<u>1,055,006,794.90</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,959,118,085.36	1,964,484,820.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,119,215.10	114,847,070.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,119,215.10	114,847,070.00
120002	Хүүгийн орлого	6.80	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,119,208.30	114,847,070.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,355,000.00	1,650,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,441,779.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,322,429.30	113,197,070.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,919,998,870.26	1,849,637,750.14
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,154,621,396.00	1,175,192,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,154,621,396.00	1,175,192,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	765,377,474.26	659,547,248.14
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	707,897,474.26	566,808,748.14
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	65,286,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,980,000.00	27,452,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	14,898,002.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	14,898,002.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,150,134,376.70	1,943,897,399.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,150,134,376.70	1,943,897,399.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,093,141,218.50	1,891,685,600.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,419,068,709.20	1,240,576,562.52
210101	Үндсэн цалин	1,419,068,709.20	999,852,705.97
210102	Нэмэгдэл	-	202,229,841.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,494,014.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,572,260.80	160,405,327.86
210201	Тэтгэврийн даатгал	94,415,409.18	118,121,303.42
210202	Тэтгэмжийн даатгал	26,203,374.04	12,955,894.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,428,137.31	7,894,084.27
210204	Ажилгүйдлийн даатгал	4,705,067.65	1,948,487.07
210205	Эрүүл мэндийн даатгал	18,820,272.62	19,485,558.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,040,601.00	5,604,869.00
210301	Гэрэл, цахилгаан	2,040,601.00	744,869.00
210304	Байрны түрээс	-	4,860,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	64,514,910.66	86,722,240.73
210401	Бичиг хэрэг	25,915,201.30	40,815,504.00
210402	Тээвэр, шатахуун	20,700,184.90	33,227,048.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,525,309.00	6,406,590.73
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,374,215.46	4,868,798.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,399,300.00
210408	Бараа материал ақталсны зардал	-	5,000.00
2105	Нормативт зардал	-	1,370,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,370,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,106,358.06	73,530,636.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,936,908.06	24,282,576.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,250.00
210604	Урсгал засвар	53,169,450.00	49,246,810.50
2107	Томилолт, зочны зардал	92,912,155.24	62,426,700.00
210701	Гадаад албан томилолт	37,403,774.00	5,499,000.00
210702	Дотоод албан томилолт	55,091,635.00	56,927,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	416,746.24	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,857,160.00	169,458,769.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,339,560.00	166,146,569.78
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,633,500.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,260,000.00	1,268,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	251,500.00	171,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210807	Газрын төлбөр	352,800.00	352,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	273,069,063.54	91,589,693.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,936,776.90	1,470,080.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,132,286.64	90,119,613.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,993,158.20	52,211,799.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,071,478.00	50,940,386.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	14,898,002.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,399,380.00	36,042,384.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,672,098.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,921,680.20	1,271,413.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,921,680.20	1,271,413.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-191,016,291.34</u>	<u>20,587,420.62</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,123,134.76	174,415.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,123,134.76	174,415.95
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-19,123,134.76	-174,415.95
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-210,139,426.10</u>	<u>20,413,004.67</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,091,788,613.24</u>	<u>1,863,287,750.14</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,946,445.00	1,650,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,946,445.00	1,650,000.00
120002	Хүүгийн орлого	6.80	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,946,438.20	1,650,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,946,438.20	1,650,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,089,842,168.24	1,861,637,750.14
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,154,621,396.00	1,175,192,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,154,621,396.00	1,175,192,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	920,448,304.24	671,547,248.14
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	862,968,304.24	566,808,748.14
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	65,286,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,980,000.00	39,452,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,772,468.00	14,898,002.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14,772,468.00	14,898,002.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,050,519,751.34</u>	<u>1,828,197,850.14</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,050,519,751.34	1,828,197,850.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,966,754,125.14	1,774,438,043.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,420,558,326.00	1,238,974,523.46
210101	Үндсэн цалин	1,274,364,726.00	995,630,008.39
210102	Нэмэгдэл	107,369,800.00	204,850,500.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,823,800.00	38,494,014.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,314,934.00	146,008,100.56
210201	Тэтгэврийн даатгал	119,098,230.00	107,368,132.87
210202	Тэтгэмжийн даатгал	6,443,343.00	9,440,967.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,054,164.00	7,786,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,610,833.00	1,946,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,108,364.00	19,466,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,990,601.00	5,604,869.00
210301	Гэрэл, цахилгаан	2,990,601.00	744,869.00
210304	Байрны түрээс	-	4,860,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,390,682.90	63,184,838.73
210401	Бичиг хэрэг	18,202,310.00	13,731,400.00
210402	Тээвэр, шатахуун	20,402,384.90	32,377,048.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,525,309.00	7,418,400.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,260,679.00	9,657,990.73
2105	Нормативт зардал	570,000.00	571,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	570,000.00	571,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,051,965.00	63,999,460.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,982,655.00	15,472,740.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	126,000.00	128,300.00
210604	Урсгал засвар	46,943,310.00	48,398,420.00
2107	Томилолт, зочны зардал	92,342,087.24	63,276,700.00
210701	Гадаад албан томилолт	37,403,774.00	5,499,000.00
210702	Дотоод албан томилолт	54,521,567.00	57,777,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	416,746.24	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,941,160.00	192,817,752.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,423,560.00	189,505,552.14
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,633,500.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,260,000.00	1,268,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	251,500.00	171,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210807	Газрын төлбөр	352,800.00	352,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	172,594,369.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	172,594,369.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,765,626.20	53,759,806.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,843,946.00	50,940,386.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,772,468.00	14,898,002.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,399,380.00	36,042,384.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,672,098.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,921,680.20	2,819,420.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,921,680.20	2,819,420.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>41,268,861.90</u>	<u>35,089,900.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,269,240.00	35,089,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,269,240.00	35,089,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,269,240.00	35,089,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-41,269,240.00</u>	<u>-35,089,900.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-378.10	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	378.10	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			778,648,992.94	778,648,992.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	778,648,992.94	778,648,992.94
Тайлант үеийн үр дүн			-210,139,426.10	-210,139,426.10
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	568,509,566.84	568,509,566.84
2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	568,509,566.84	568,509,566.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	568,509,566.84	568,509,566.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		466,084,223.39		466,084,223.39
Тайлант үеийн үр дүн			20,413,004.67	20,413,004.67
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	466,084,223.39	588,922,571.51	1,055,006,794.90

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,176,842,500.00	1,175,571,086.76	1,271,413.24	99.89%
УРСГАЛ ЗАРДАЛ	1,176,842,500.00	1,175,571,086.76	1,271,413.24	99.89%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,140,800,100.00	1,139,528,702.76	1,271,397.24	99.89%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	973,297,700.00	972,967,915.07	329,784.93	99.97%
Үндсэн цалин	729,623,400.00	729,623,400.00	-	100.00%
Нэмэгдэл	204,850,500.00	204,850,500.40	-0.40	100.00%
Унаа хоолны хөнгөлөлт	38,823,800.00	38,494,014.67	329,785.33	99.15%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,795,800.00	116,086,959.69	708,840.31	99.39%
Тэтгэврийн даатгал	77,863,800.00	77,863,800.00	-	100.00%
Тэтгэмжийн даатгал	9,733,000.00	9,024,159.69	708,840.31	92.72%
ҮОМШӨ-ний даатгал	7,786,400.00	7,786,400.00	-	100.00%
Ажилгүйдлийн даатгал	1,946,600.00	1,946,600.00	-	100.00%
Эрүүл мэндийн даатгал	19,466,000.00	19,466,000.00	-	100.00%
Хангамж, бараа материалын зардал	18,900,200.00	18,895,618.00	4,582.00	99.98%
Бичиг хэрэг	4,019,200.00	4,019,200.00	-	100.00%
Тээвэр, шатахуун	7,278,800.00	7,274,218.00	4,582.00	99.94%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,378,400.00	6,378,400.00	-	100.00%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,223,800.00	1,223,800.00	-	100.00%
Нормативт зардал	571,800.00	571,800.00	-	100.00%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	571,800.00	571,800.00	-	100.00%
Эд хогшил, урсгал засварын зардал	12,988,300.00	12,988,300.00	-	100.00%
Багаж, техник, хэрэгсэл	7,114,100.00	7,114,100.00	-	100.00%
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	128,300.00	128,300.00	-	100.00%
Урсгал засвар	5,745,900.00	5,745,900.00	-	100.00%
Томилолт, зочны зардал	10,619,300.00	10,610,700.00	8,600.00	99.92%
Дотоод албан томилолт	10,619,300.00	10,610,700.00	8,600.00	99.92%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,627,000.00	7,407,410.00	219,590.00	97.12%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,095,300.00	4,095,210.00	90.00	100.00%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,633,500.00	1,500,000.00	133,500.00	91.83%
Даатгалын үйлчилгээ	1,268,600.00	1,268,600.00	-	100.00%
Тээврийн хэрэгслийн татвар	257,000.00	171,000.00	86,000.00	66.54%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00	-	100.00%
Газрын төлбөр	352,800.00	352,800.00	-	100.00%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,042,400.00	36,042,384.00	16.00	100.00%

Бусад урсгал шилжүүлэг	36,042,400.00	36,042,384.00	16.00	100.00%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,042,400.00	36,042,384.00	16.00	100.00%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,176,842,500.00	1,175,571,086.76	1,271,413.24	99.89%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,175,192,500.00	1,173,921,086.76	1,271,413.24	99.89%
Улсын төсвөөс санхүүжих	1,175,192,500.00	1,173,921,086.76	1,271,413.24	99.89%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,650,000.00	1,650,000.00	-	100.00%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,650,000.00	1,650,000.00	-	100.00%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00%
Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	98.00	98.00	-	100.00%
Удирдах ажилтан	4.00	4.00	-	100.00%
Гүйцэтгэх ажилтан	80.00	80.00	-	100.00%
Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.00%
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	98.00	98.00	-	100.00%
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	11.00	11.00	-	100.00%
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	87.00	87.00	-	100.00%

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		671,547,248.14	-671,547,248.14	
УРСГАЛ ЗАРДАЛ		671,547,248.14	-671,547,248.14	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		669,999,241.13	-669,999,241.13	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		266,006,608.39	-266,006,608.39	
Үндсэн цалин		266,006,608.39	-266,006,608.39	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		29,921,140.87	-29,921,140.87	
Тэтгэврийн даатгал		29,504,332.87	-29,504,332.87	
Тэтгэмжийн даатгал		416,808.00	-416,808.00	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		5,604,869.00	-5,604,869.00	
Гэрэл, цахилгаан		744,869.00	-744,869.00	
Байрны түрээс		4,860,000.00	-4,860,000.00	
Хангамж, бараа материалын зардал		44,289,220.73	-44,289,220.73	
Бичиг хэрэг		9,712,200.00	-9,712,200.00	
Тээвэр, шатахуун		25,102,830.00	-25,102,830.00	
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,040,000.00	-1,040,000.00	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		8,434,190.73	-8,434,190.73	
Эд хогшил, урсгал засварын зардал		86,101,060.00	-86,101,060.00	
Багаж, техник, хэрэгсэл		43,448,540.00	-43,448,540.00	
Урсгал засвар		42,652,520.00	-42,652,520.00	
Томилолт, зочны зардал		52,666,000.00	-52,666,000.00	
Гадаад албан томилолт		5,499,000.00	-5,499,000.00	
Дотоод албан томилолт		47,167,000.00	-47,167,000.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		185,410,342.14	-185,410,342.14	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		185,410,342.14	-185,410,342.14	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,548,007.01	-1,548,007.01	
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,548,007.01	-1,548,007.01	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1,548,007.01	-1,548,007.01	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		671,547,248.14	-671,547,248.14	
Нэмэлт санхүүжилтийн орлого		671,547,248.14	-671,547,248.14	
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		566,808,748.14	-566,808,748.14	
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		65,286,000.00	-65,286,000.00	

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		39,452,500.00	-39,452,500.00	
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.22	Аудитын нэр: Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код: САГ-2019/75/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6	7
1	Худалдан авсан хангамж, бараа материал, тогтмол зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн	14,403.2	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Г.Сарантуяа Д.Энхсайхан
2	Хувь хүнтэй хийсэн гэрээний дагуу олгосон гражийн түрээс, машины түрээс гэх мэт түрээсийн орлогоос суутгасан татварыг ТТ-11-2 дугаар мэдээ буюу "гэрээгээр олгосон хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос суутган тооцсон татварын мэдээ" -нд оруулж тайлагнасан	3,035.5	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Г.Сарантуяа Д.Энхсайхан
3	Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу кассын тайланг гаргаж ажиллаагүй, касс дахь мөнгөний үлдэгдлийн тооллого тооцоо хийгээгүй.	-	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Г.Сарантуяа Д.Энхсайхан
Нийт		17,438.7					

